



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/А98

Булган сум

А.Амарын мэндэлсний 140 жилийн ойг
тэмдэглэн өнгөрүүлэх, бэлтгэл ажлыг хангах
ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 206 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 25-ны IV/25 дугаар тогтоолын 4.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Ерөнхий сайд агсан Агданбуугийн Амарын мэндэлсний 140 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

- Ажлын хэсгийн дарга: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)
- Гишүүд: Б.Насанжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
- М.Батчимэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- Т.Нямхүү (Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа)
- Э.Эрболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны ажилтан)
- Ё.Хулан (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
- З.Батзориг (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, зөвшилцсөнөөр)
- Ц.Цолмонбаатар (Боловсролын газрын дарга)
- Т.Мөнгөнтуяа (Нийтийн номын сангийн захирал)
- Т.Бэхтөр (Музейн захирал)

6315011114

О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
Х.Ууганбаяр (Бугат сумын Засаг дарга)
Н.Батболд (Түүхийн ухааны доктор, Тагнуулын
ерөнхий газрын Тусгай архивын эрхлэгч, хошууч,
зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: Б.Отгонсүвд (Аймгийн Засаг даргын тамгын
газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
Шийдвэрийн биелэлт, шагнал хариуцсан
мэргэжилтэн)

2.А.Амарын алдар гавьяаг мөнхжүүлэх, намтар, үйл хэргийг иргэд, олон нийт,
залуучууд хойч үедээ сурталчлан таниулах, Булган аймаг байгуулагдсаны 90 жилийн
ойн бэлтгэл хангах чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллахыг ажлын хэсгийн дарга
(Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

